



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 6 дугаар
сарын 05 өдөр

Дугаар 6-137

Улаанбаатар
хот

Төвийн дүрэм батлах, ажилд
улируулан томилох тухай

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Элөгний эмгэг эмчлэх монгол эмнэлэг төв"-ийн дүрмийг хэвсрэлтээр баталсугай.

2. "Элөгний эмгэг эмчлэх монгол эмнэлэг төв"-ийн захирлаар Жамбалын Хатанбаатарыг улируулан томилж, Засгийн газрын 1997 оны 88 дугаар тогтоолыг үндэслэн сарын үндсэн цалинг 40375 төгрөгөөр тогтоож, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хэвсрэлтын дагуу ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 15 хувиар, мөн тогтоолын 5 дугаар хэвсрэлтыг үндэслэн мэргэжлийн зэргийн нэмэгдлийн хэмжээг үндсэн цалингийн 15 хувиар тус тус бодож олгохыг тус төвийн нягтлан бодогч (н.Лутaa)-д зөвшөөрсүгэй.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/71 дүгээр захирамжийн 1 дүгээр заалтын "тус төвийг Засаг даргын Нийтлэг үйлчилгээний газрын харъяалалд оруулсан" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БЭГДЭД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ

Нийслэлийн Засаг даргын 1997 оны
6-13/ тоот захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭЛЭГНИЙ ЭМГЭГ ЭМЧЛЭХ МОНГОЛ ЭМНЭЛ- ГИЙН ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх элэгний эмгэг эмчлэх монгол эмнэлгийн төв нь (цаашид төв гэх) нийслэл Улаанбаатар хотын болон 21 аймгийн нийт хүн амд үйлчилж таван цул, зургаан сая Эрхтний өвчин эмгэгийг уламжлалт анагаах ухааны аргаар эмчлэх, эмчилгээний явц үр дүнг судлах, үг өвчнүүдийг төгс эмчлэх зорилгоор тодорхой хутацаагаар сувилах, эмчилгээ сувилгаанд шаардагдэх эмийн түүхий эдийг дотоод, гадаадаас бэлтгэж уламжлалт монгол аргаар эм тэнг үйлдвэрлэх, эмчилгээний явцад хяналт хийх, эмчилгээ оношлогооны үйл явцыг тодруулах зорилгоор иж бүрэн лабораторитойгоор ажиллах үндсэн үүрэгтэй Нийслэлийн Засаг даргын дэргэдэх төрийн үйлчилгээний төсөвт байгууллага мөн.

1.2. Төв нь үйл ажиллагаандаа монгол улсын эрүүлийг хамгаалах хууль, Нийгмийн эрүүл мэндийн даатгалын хууль болон бусад хуулиуд, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нийслэлийн Засаг даргын тогтоол, захирамж энэ дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Төв нь нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын өдөр тутмын болон Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, мэргэжлийн удирдлагын дор ажиллаж, Засаг дарга, түүний Тамгын газарт ажлаа тайлагнана.

1.4. Монгол эмнэлгийн төв (МЭТ)-ийн бүтэц нь:

–Амбулаторийн үйлчилгээ. Үүнд:

–Оношлогоо эмчилгээ, хануур самнуур, үзлэг–судсын оношлогоо, зүү төөнүүр, түрэм заслын, Хатха–юг, цэгийн иллэг, шавар–рашаан усны эмчилгээ, шүд, хэт дууны өвчин оношлогоо, зүрхний цахилгаан бичлэг, эмэгтэйчүүдийн эмчилгээний, Рентген, лабораторийн үйлчилгээ.

–Лабораторийн үйлчилгээ. Үүнд:

- Биохимийн
- Клиникийн
- Вирусийн оношлогооны

Стационарийн үйлчилгээ:

–60 ортой хоёр тасагт элэгний архаг үрэвсэлтэй өвчтөнүүдийг хүлээн авч уламжлалт монгол анагаах ухааны аргаар эмчилнэ.

–Эмчилгээний дараах гэм хийх, эмчилгээг төгөлдөржүүлэх, хүндрэлээс сэргийлэх сувидал /30–40 ортой/ Үүнд:

/улирлын ажиллагаатай цагаан гүүний 10–12 ортой сувидал/

–Эмийн үйлдвэр. Үүнд:

–Эм тэнг үйлдвэрлэлийн хэсэг

–Дотуур, гадуур үйлчилгээтэй эмийн сан

–Уламжлалт анагаах ухааны аргаар элэгний архаг үрэвсэл өвчнийг эмчлэх арга замын талаар судалгаа шинжилгээний ажил явуулах эрдэм шинжилгээний ажлын хэсэг.

1.5. Төвийн бүтэц, орон тоог Нийслэлийн Засаг дарга тогтоож, төвийн захирлыг томилж чөлөөлнө.

1.6. Төвийг нийслэлийн Засаг даргын томилсон захирал удирдана. Захирлын дэргэд түүний тушаалаар баталсан захирлын зөвлөл ажиллана.

1.7. Тус төв нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, данстай хуулийн этгээд байна.

1.8. Төвийн захирал эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

Хоёр. Монгол эмнэлгийн төвийн үүрэг

2.1. Дүрмэнд заасны дагуу хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажиллагаагаа тус улсын эрүүл мэндийн хууль болон бусад хууль дүрмийн хүрээнд явуулах ба төсвийн хуулийн дагуу зарцуулна.

2.2. Төв нь элэгний архаг өвчтэй хүмүүсийг стационариар хүлээн авч монголын уламжлалт оношлогооны (судас барих, ус, хэл харах, эмийн тодруулга хийх) аргыг орчин үеийн оношлогооны дэвшилттэй аргатай хослуулан, ашиглаж оношлох ба уламжлалт аргыг гол болгон эмчилж үр дүнг судлан тооцно.

2.3. уламжлалт анагаах ухааны аргаар эмчилгээ үйлчилгээ явуулах эмнэлгийн дээд, дунд мэргэжилтэн нарт мэргэжил олгох курс хичээллүүлж, мэргэжил дээшлүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

2.4. Хууль зүйн болон шинжилгээ судалгааны үндсэн баримт болох эмнэлгийн анхан шатны бичиг баримтыг бүрэн хөтөлж, тайлан тооцоог гаргах ба уламжлалт анагаах ухааны аргаар элэгний архаг үрэвсэл өвчнийг эмчлэх явцын талаар судалгаа шинжилгээний ажлыг хийх.

2.5. Үйлчлүүлэгчдийн эрх ашиг, үүрэгт нь зохицуулан бүх өвчтөнүүдийг анхан амбулаториор хүлээн авч үйлчилнэ. харин бүх төрлийн хавдар, сэхээн амьдруулах эмчилгээ шаардлагатай өвчин, хурц халдварт өвчин ба мэс засал гэмтлийн чиглэлийн өвчнийг хүлээн авахгүй.

2.6. Амбулаториор уламжлалт эмчилгээний аргаар эмчлэгдэж болох бүх төрлийн (2-5 заагдсанаас бусад) өвчтөнүүдийг хүлээн авах ба нутаг дэвсгэр харгалзахгүй үйлчилж, эмнэлгийн стационарт элэгний архаг үрэвсэлт өвчтэй хүмүүсийг хэвтүүлэн эмчлэх ба эмчилгээний явцыг судалгааны явцын гол үзүүлэлт болгон ашиглана.

2.7. Эмчилгээ явуулахад шаардагдах монголын уламжлалт жороор хийгдэх эмүүдийг үйлдвэрлэх эмийн үйлдвэр, гадуур (амбулатори-д) дотуур (стационарид) үйлчлэх хоёр талын ажиллагаатай эмийн санг тус тус ажиллуулна.

2.8. Эмнэлгийн байгууллагуудад хөтөлөгдөх анхан шатны бичиг баримтуудыг бүрэн хөтөлж, гаргаж өгөх, хутацаатай тайлан мэдээг тухай бүр нь зохих байгууллагад гаргаж өгч байна.

Гурав. Монгол эмнэлгийн төвийн эрх

3.1. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр Элэгний өвчнийг эмчлэх ажлын чиглэлээр нутаг дэвсгэрийн хүрээнд авах арга хэмжээний талаар санал боловсруулж нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллагад оруулах.

3.2. Эрүүл мэндийн болон уламжлалт анагаах ухааны чиглэлээр байгууллагуудаас мэдээ судалгаа авах, төлбөртэй сургалт явуулах, туршлага судлан солилцуулахаар гадаад дотоодын курст, семинарт ажилтнуудыг хамруулах үйлчилгээний зардал гаргуулах.

3.3. Уламжлалт Монгол анагаах ухааны чиглэлээр ажиллаж байгаа (өмчийн ялгаа харгалзахгүй) бусад эмнэлгүүдэд мэргэжлийн зөвлөлгөө өгөх, тэдгээрийн үйл ажиллагаанд туслах.

3.4. Хууль тогтоомжинд нийцээгүй зөрчил, дутагдлыг арилгуулахаар холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, ажиллагсдын нэр төр, эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн асуудлаа боловсруулж тавих.

3.5. Өөрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, эмийн түүхий эдийг бэлтгэх зорилгоор гадаад харилцааг хөгжүүлэх.

3.6. Уламжлалт монгол анагаах ухааны ном, судрыг орчуулах, хийгдэж байгаа эрдэм шинжилгээний ажлын талаар мэдээ материал хэвлэх, хэвлүүлэх, олшруулах.

3.7. Өөрийн эмийн үйлдвэрт үйлдвэрлэсэн эмийн бодит үнийг ЭМЯ-ны үнийн жишигт ойртуулан тогтоож, нийслэлийн болон ЭМЯ-ны үнийн зөвшлийн комисст саналаа тавьж шийдвэрлүүлэхийн зэрэгцээ захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн эмийн үнийг баталж мөрдүүлэх.

3.8. Үйлдвэрлэж байгаа эмүүдийг улсын бүртгэлд бүртгүүлэх, стандарт боловсруулах, патент авах.

3.9. Ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөлийг тогтоох, хөнгөлөлт эдлүүлэх, өвчтөний хоол хүнсний хангамж сайжруулах, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд туслах зорилгоор туслах аж ахуй эрхлэх.

3.10. Уламжлалт монгол эмнэлгийн цаашид хөгжүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бүэлтгэх, эмч эмчилгээний ажилчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, туршлага судлах зорилгоор гадаадын орноос эмч мэргэжилтнүүдийг урьж ажиллуулах.

3.11. Төвд ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг шилж сонгох, цаашид ажилд дэвшүүлэх, сургууль курст явуулах, шагнаж урамшуулах арга хэмжээ авах асуудлаар холбогдох эрх бүхий байгууллагад санал оруулах, тодорхойлох.